МЭДЭЭ · 2020 оны 4-р сарын 10

ХАМТАРСАН УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЖЭЭ



Баянгол дүүргийн Прокурорын газар болон тус дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хамтарсан уулзалт зохион байгуулжээ.





Уулзалтаар дүүргийн Прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч прокурор Б.Эрхэмбаяр “Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт”, дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч О.Жанчивнямбуу “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад прокурор, мөрдөгчөөс анхаарвал зохих асуудал” сэдвээр тус тус мэдээлэл хийж, санал солилцсон байна.

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/3098